



01052

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 132

Мөрөн

Орон нутгийн өмчид хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “а” заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчлөлд байгаа дулаан, цэвэр усны шугам сүлжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өргөтгөл хийсэн 648.999.996 төгрөгийн өртөгтэй 13 ширхэг дулаан дамжуулах төв, 18.438.292.954 төгрөгийн өртөгтэй 41.0 км урт дулаан, ундны болон хэрэглээний цэвэр ус дамжуулах шугамыг Хөвсгөл аймгийн өмчид бүртгэж, “Хөвсгөл Ус Суваг” ХХК-д эзэмшүүлэхийг аймгийн Засаг дарга /Л.Ганболд/-д даалгасугай.

2. Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчлөлийн 648.999.996 төгрөгийн өртөгтэй 13 ширхэг дулаан дамжуулах төв, 18.438.292.954 төгрөгийн өртөгтэй 41.0 км урт дулаан, ундны болон хэрэглээний цэвэр ус дамжуулах шугам, сүлжээг “Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн хөрөнгийн бүртгэлээс хасч, тус компанийн санхүүгийн тайланд залруулга хийж өгөхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүссүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Гончиг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

010552